



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒5 оны ᠐᠖ сарын ᠒᠖ өдөр

Дугаар А/153

Улаанбаатар хот

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 14,713,600.00 (арван дөрвөн сая долоон зуун арван гурван мянга зургаан зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ (Д.Отгонбаатар)-т зөвшөөрсүгэй.
2. Данснаас хасагдаж буй 4 нэр төрлийн 12,258,400.00 (арван хоёр сая хоёр зуун тавин найман мянга дөрвөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 1 нэр төрлийн 2,455,200.00 (хоёр сая дөрвөн зуун тавин таван мянга хоёр зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 20,000.00 (хорин мянган) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 6,000.00 (зургаан мянган) төгрөгийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ (Д.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.
- 3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.



ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА

۳. دھریکے میں ریسرچنگ سے فی ریشم بیویوں سے کھسوسے کے درختوں کی . مہماتوں کی ندر ریسرچ (۵۰
مہماتوں) -۵۰ مہماتوں کی ..



۴. مہماتوں کی

مہماتوں کی

